



БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ  
ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ  
ТОГТООЛ

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Дотоод аудитын дүнгийн тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалт, Засгийн газрын 2015 оны "Дотоод аудитын дүрэм батлах тухай" 483 дугаар тогтоол, Сангийн сайдын 2019 оны 29 дүгээр тушаалаар батлагдсан "Дотоод аудитын хорооны дүрэм"-ийн 3.6, 4.1.2 дахь заалт, Дотоод аудитын хорооны 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хурлын тэмдэглэл, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Дотоод аудитын хорооны 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсанаар "Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний 2020 оны эхний хагас жилийн худалдан авах ажиллагаа"-нд хийсэн дотоод аудитын тайлангийн дүгнэлт, үр дүнг хэлэлцэн дотоод аудитын хорооны хурлаас ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын эрхлэх асуудлын хүрээний 2020 оны эхний хагас жилийн худалдан авах ажиллагаанд хийсэн дотоод аудитын санал, зөвлөмжийг хавсралтаар баталсугай.

2. Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг 2020 оны 08 дугаар сарын 25-ны дотор Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэхийг Төрийн нарийн бичгийн дарга, нэгжийн дарга нар, Цэвэр технологи, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэст үүрэг болгосугай.

3. Дотоод аудитын ажлын тайлан, хорооны тогтоолыг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, зөвлөмжийн биелэлтийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллан, үр дүнг танилцуулахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга В.Жавзанд даалгасугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД,  
ДОТООД АУДИТЫН ХОРООНЫ  
ДАРГА



Н.ЦЭРЭНБАТ

Дотоод аудитын хорооны 2020 оны  
06 дугаар сарын 29-ны өдрийн  
31 дугаар тогтоолын хавсралт

Төрийн нарийн бичгийн дарга,  
нэгжийн дарга нар, Цэвэр технологи,  
хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэст

1.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулахдаа Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ыг баримтлан зөв төлөвлөж батлуулах, техникийн алдаа гаргахгүй байх, дотоод хяналтыг сайжруулж ажиллах;

2.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хугацааг баримтлан, хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах, гүйцэтгэлд онцгойлон анхаарах;

3.Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангах хялбаршуулсан зөвлөмж"-ийг мөрдөж ажиллах;

4.Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдөр баталсан "Салбарын хэмжээнд төрийн албан хэрэг хөтлөлтийг стандарт, журмын дагуу мөрдөх хялбаршуулсан зөвлөмж"-ийг хэрэгжүүлэн мөрдөж ажиллах;

5.Тендерийн баримт бичгийг Төрийн нарийн бичгийн даргын гарын үсэг, огноо, тамгаар бүрэн гүйцэд баталгаажуулснаар цахим системд байршуулж, Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар баталсан "Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам"-ыг мөрдөж ажиллах;

6.Худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд заасан хугацаанд зохион байгуулахгүй нийтлэг зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.7-д "хууль, гэрээнд зааснаас бусад тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулахгүй байх" заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах;

7.Худалдан авах ажиллагааны үнэлгээний хороог төлөвлөсөн хугацаанд зохион байгуулаагүй, ажил гүйцэтгэх гэрээг хугацаанд нь хийж гүйцэтгээгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах;

8.Эрх шилжүүлсэн ажлуудын төлөвлөсөн хугацаа, гүйцэтгэл, чанар, үр дүн, гэрээний хэрэгжилтэд Санхүүгийн болон Цэвэр технологи, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс хамтран дотоод хяналт тавин ажиллах;

9.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40 дүгээр зүйлийн дагуу гэрээ байгуулахдаа тендерийн жишиг бичиг баримтад заасан шаардлагыг бүрэн гүйцэд гэрээний заалт бүрээр тусган баталгаажуулах;

10.Байгаль орчин, аялал жуулчлалын яамны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Ойн судалгаа хөгжлийн төв улсын төсөвт үйлдвэрийн газрын төлөвлөсөн ажлаас "Ойн цэвэрлэгээ хийх талбай, нөөцийн судалгаа хийх, зураглал гаргах, төсөл боловсруулах" ажлын үнийн дүнг 124.2 сая төгрөгөөр илүү тооцож буруу төлөвлөснийг Цэвэр технологи, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс залруулах арга хэмжээ авч ажиллан, удирдлагад танилцуулах;

11. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газрын төлөвлөсөн ажлаас "Говь, хээрийн бүсийн булаг, шандыг хамгаалах, нөхөн сэргээх" 81.0 сая төгрөг, "Монгол орны нутаг дэвсгэрт ургасан рапсын эрсдэлийн үнэлгээ хийх" 40.0 сая төгрөгийн ажлууд давхацсан тул нэгдсэн төлөвлөгөөнд Цэвэр технологи, хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс зохих журмын дагуу залруулах арга хэмжээг авч, удирдлагад танилцуулах;

12. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан нийт 101 ажлаас үнэлгээний хороо байгуулаагүйгээс хоцрогдолтой дүгнэгдсэн Төрийн захиргааны удирдлагын газрын 2, Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын 1, Аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын 7, нийт 10 ажлыг хууль тогтоомжийн дагуу нэн даруй шийдвэрлэж, ажлын гүйцэтгэлийг эрчимжүүлэх;

13. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер шалгаруулалтын хавтаст хэргийг бүрэн гүйцэд бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалах, хуулийн хугацаанд хүлээлгэн өгч хадгалж хэвших;

14. Архивын ерөнхий газрын даргын 2009 оны А/68 дугаар тушаал, Стандартчилал, хэмжил зүйн газраас 2011 онд баталсан "Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт"-д заасны дагуу үнэлгээний хорооны хурал хийсэн тухай бүрд тэмдэглэл хөтөлж, шийдвэрийг гишүүдээр гарын үсэг зуруулан баталгаажуулж хэвших;

15. Өмнөх онуудад хийсэн дотоод аудитын зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлээгүй, тайлан ирүүлээгүй холбогдох албан тушаалтан, асуудал хариуцсан мэргэжилтэнд хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох, дотоод аудитаас өгсөн зөвлөмжийн биелэлтийг хугацаанд нь ирүүлж хэвших;

16. Зөвлөмжийн хэрэгжилтийг нотлох баримтаар бүрдүүлэн 2020 оны 08 дугаар сарын 25-ны дотор Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлж ажиллахыг зөвлөж байна.

## ДОТООД АУДИТЫН ХОРОО